



# МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО

## ЗОХИОЛЫН ГАДААД ОРЧУУЛГА



## ЧАМБАЙ ЭРДЭМТНИЙ ЧАМБАЙХАН ОЛЗ



*МУ-ын гавьяат багш,  
д-р(Sc.D), проф. С.Галсан  
/ Хэл судлаач Дээд Сургуулийн захирал/*

Жинхэнэ эрдэмтэн хүн бол байнгын эрэлхийлэгч байдаг. Бас байнгын бодлогоширогч мөн. Жинхэнэ эрдэмтэн хүн байнгын уншигч байхын зэрэгцээ мөнхийн бодлогоширогч, бясалгагч байх учиртай. Агуу их Эйнштэйн өдөр шөнөгүй, толгой өөд таталгүй ном уншдаг нэгэн аспирантдаа “Та чингэхэд хэдийд нь бодож бясалгадаг хүн байна даа” гэж зэмнэлгүй айлдсан нэгэн явдал байдаг.

Доктор Сумъяабаатар бол мөнхийн эрэлхийлэгч бөгөөд маш их ажилсаг эрдэмтнээс гадна бусдын ухаантайхан айлдварын бүхэл бүтэн нандин цуглуулга гэж болно.

Оюун ухааны сувдан хэлхээг Сумъяабаатар шиг уйгагүй хэлхэж баймааж нь эрдэмтний дотоод сэтгэлийн гэгээ бадрах нэгэн нөхцөл болно. Одоогоос олон арван жилийн өмнө агуу их Дамдинсүрэн гуай “Нууц товчоо”-г 13-р зууны монгол хэлнээс орчин цагийн монгол хэлэнд буулгахдаа “Монгол хэлнээс монгол хэлэнд орчуулна гэдэг хачин мэт бодогдож болох боловч миний хийсэн ажил бол жинхэнэ орчуулга байсан юм” гээд хэд хэдэн тодорхой жишээ татсан байдаг нь Дамдинсүрэн гуайн Нууц товчоо бол чухамдаа үнэнхүү л орчуулга байж дээ гэж тэр үед л бодогдуулж байсныг одоо эргэн санахад уг дүгнэлтийн өнгө аяс хуучраагүйгээр үл барам цагийн аяст улам тод гялалзах мэт болдог нь Их хүний их бүтээлийн шинж аргагүй мөн.

“Монголын нууц товчоо” гэдэг энэ агуу их зохиол дэлхийн монгол судлаачдын анхааралд өртөөд бас л хэдэн арван жил өнгөрчээ.

Дэлхийн Монголч эрдэмтний сүүлийн нэг хурал дээр л гэхэд Дэлхийн Монголч эрдэмтний холбооны Ерөнхийлөгч миний дотны найз проф.Озава / Японы/ Нууц товчоог нарийн сайн судлая гэвэл заавал Хятадын эртний ханзыг мэдэх шаардлагатай гээд өөрөө самбарт шохой бариад дурайтал баталсан нь нэгэн зүйлийг хэлж байгаа юм.

Гэтэл Нууц товчооны эртний ханзыг нь ханз болгонд нь тааруулан

монгол үгийг үечлэх аргаар хадаж (хуучин бичгээр ) хавсаргасан нэгэн ховор номыг Хэлний хүрээлэнгийн номын сангаас эрдэмтэн Сумъяабаатар л олж Солонгост хэвлүүлсэн нь “Нууц Товчоо”-ны Төрийн ордонд залах бодит хувилбар нь ч байж болох гэлтэй. Энэ бол нээлт байна.

Гүн Гомбожав, Дамдинсүрэн гуай хоёр энэхүү хадмал орчуулгыг харсан гэхэд хараагүй ч юм шиг, хараагүй гэхэд харсан ч баймаар сонин нэгэн гогцоо энд гарч байна. Зөвхөн эхний хуудаснаас нь л харахад Дамдинсүрэн гуай орчуулгад байхгүй үг, хэллэг энд байж байх жишээтэй.

Хэрвээ судлаачид энэ орчуулгыг (үечлэн хадсан хадмал орчуулга) харсан бол эрх биш дурьдмаар юм. Дурьдахгүй байхын ч аргагүй бүтээл юм.

Бас нэгэн сонин зүйл бол Нууц товчооны гарчирийн асуудал мөн. Энэ номд хэлэхдээ: “Монголын нууц түүхийн Хятадаас орчуулж буй (орчуулга) үүний дотор буй. Судар бичгийн хүрээлэн амой” гэсэн хуучин бичгээр гараар бичсэн бийрийн бичиг бололтой маш сонин гарчиг тодоос тод дурайна.

Энд уг зохиолыг “Монголын нууц товчоо” гээгүй “Монголын нууц түүх” гэсэн байгаа биз. Англиар мөн “Нууц түүх” гэдэг. Гэтэл оросоор болохоороо “Сокровенное сказание Монголов” болгож хэтэрхий утгачилсанаас гадна үүнийг эргүүлээд монголчилбол “Монголын” бус “Монголчуудын” гэсэн үг гарна. Энэ бол агуу их Козин гуайн орчуулга. “Монголия-Монголы” хоёр бол өдөр шөнө шиг хоёр өөр үг . Англиар “Нууц түүх” гэж хэлээд байгаа нь Хятад ханзнаас буулгасан анхны монгол эхтэй яв цав дүйж байгаа нь их сонин зүйл.

Эрдэмтэн Сумъяабаатарын олсон энэ эхийг Дамдинсүрэн гуайн орчуулгатай үг, үсэг болгоныг дүйлгэвэл олон олон сонин зүйл ажиг болох байх аа. Над даанч зав алга даа.

### Тодорхой санал

*Нэг.* “Нууц товчоо” судлаачдын бүтээлд алинд нь ч дурьдаагүй бөгөөд эртний хятад ханзнаас үечлэн буулгасан энэхүү Эхийг Ордондоо залах нь зүйтэй.

*Хоёр.* Энэхүү Эхэд дурьдсанаар уг номыг “Монголын нууц товчоо” биш /орос орчуулгаар бол “Монголчуудын” /монголов/ болно. Энэ бол бүр ч биш! Харин “Монголын нууц түүх” хэмээн нэрлэвээс зохилтой.

*Гурав.* “Монголын нууц түүх” хэмээх нүүдэлчдийн энэхүү агуу их бүтээлийг судалж, бас орчин цагийн монгол хэлнээ орчуулсан манай нэрт эрдэмтэд Цэнд гүн, Ц.Дамдинсүрэн, Ш.Гаадамба, Д.Цэрэнсодном нар болон уг номыг дэлхий дахинаа түгээсэн алдарт эрдэмтэн орчуулагчид Н.Козин /Оросын/, Пеле /Францын/, Э.Хениш, В.Хайсиг /Германы/, Т.Поуха /Чехийн/, Л.Лигети /Унгарын/, С.Калужински /Польшийн/ зэрэг нэрийг номын төгсгөлд нь алтан үсгээр хавсаргаж мөнхжүүлүүштэй.